



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө хүлээн авах,
бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 110 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 39,363,032.00 (гучин есөн сая гурван зуун жааран гурван мянга гучин хоёр) төгрөгийн балансын үнэ, 2,915,780.14 (хоёр сая есөн зуун арван таван мянга долоон зуун наян төгрөг арван дөрвөн мөнгө) төгрөгийн хурумтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу төрийн өмчид хүлээн авч, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Ховд аймаг дахь Шүүхийн шинжилгээний албандаа эзэмшүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал, цагдаагийн хурандаа Д.Ядамдорж, Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ш.Нохойжав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

2.4. Энэ тогтоолыг Улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлж, эзэмшигч өөрчлөгдсөнийг мэдэгдэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13201088

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ХӨРӨНГИЙГ ТӨРИЙН
ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ, ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭНГИЙН ХОВД
АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНД ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон он	Нийт балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (өртөг)
1	Орон сууцны 2 өрөө байр (Ховд аймгийн Жаргалант сум, Жаргалан баг, 2-р хороо, 80 айлын орон сууцны 12 тоот, 2 өрөө)	2002.01.01	39,363,032.00	2,915,780.14	36,447,251.86
	Нийт дүн		39,363,032.00 (гучин есөн сая гурван зуун жаран гурван мянга гучин хоёр)	2,915,780.14 (хоёр сая есөн зуун арван таван мянга долоон зуун наян төгрөг арван дөрвөн мөнгө)	36,447,251.86 (гучин зургаан сая дөрвөн зуун дөчин долоон мянга хоёр зуун тавин нэгэн төгрөг наян зургаан мөнгө)